



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ИЛ ТОД БАЙДАЛ

2026 оны 06 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Засгийн газрын 2025 оны 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд компанийн шинэчилсэн бүтэц, орон тоог Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 09 дүгээр тогтоолоор дэмжүүлж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 195 дугаар тогтоолоор батлуулан 950 орон тоотойгоор ажиллаж ирсэн бөгөөд “Монголын төмөр зам” ТӨХК ба “Чайна энерги коксжих нүүрс (Тяньжин)” ХХК хооронд байгуулагдсан урт хугацааны нүүрс тээвэрлэлтийн гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд Зам, тээврийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар нүүрс тээвэрлэлтийг эрчимжүүлэх тухай” А/209 тоот тушаалаар “Монголын төмөр зам” ТӨХК-ийн төв оффист ажиллаж байгаа ажилтнуудын 40 хувийг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд татан оролцуулж, орон нутагт ажиллуулах, улмаар тээвэрлэлтийг 24 цагаар тасралтгүй явуулах, тээвэрлэлтэд хяналт тавих зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захиралд даалгасан.

Дээрх ажлын хүрээнд компанийн бүтэц, орон тоонд багтаагүй, төмөр замын тээврийн аюулгүй байдал, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай ажлын байранд “гэрээт”-ээр ажиллаж байсан ажилтнуудын үндсэн орон тоонд шилжүүлж шаардлага үүссэн тул “Эрчист Монгол” ХХК, Зам, Тээврийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 9 сарын 29-ний өдрийн “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай” 24 дүгээр тогтоолоор орон тооны дээд хязгаарыг **1280**, гэрээт ажилтан 131 байхаар тогтоосны дагуу 6 газар, 12 хэлтэс, 3 өртөө, 12 зөрлөг, 5 анги, 6 хэсэг, 3 депо, 6 терминал, 1 төсөл хөтөлбөр, судалгаа, зураг төслийн төв, 1 төслийн нэгжтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн бүтэц, орон тоог шинэчлэн баталсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2025 оны А/209 дугаар тушаалаар байгуулагдсан “Ажлын хэсэг” нийт 305 ажлын байранд “Албан тушаалын тодорхойлолт”-ыг нийцүүлэн боловсруулж Гүйцэтгэх захирлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Ажлын байрны сул орон тоо гарсан үед ажлын байрны зарыг компанийн www.mtz.mn сайт, нийгмийн сүлжээний хэрэгслүүд болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан байршуулдаг бөгөөд сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд нээлттэйгээр зохион байгуулж байна.

Компани нь Гүйцэтгэх захирлын 2017 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн А/78 дугаар тушаалаар “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг баталсан бөгөөд компанийн үйл ажиллагаа өргөжиж ажиллах хүн, хүч нэмэгдэж байгаатай холбогдуулан ажилтнуудын ажиллах нөхцөл, эрх зүйн орчин, нийгмийн баталгааг хангах зорилгоор “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг дагалдах багц дүрэм журмуудын хамт мэргэжлийн байгууллагаар шинэчлэн боловсруулахаар “Сольюшн Менежмент Групп” ХХК-тай хамтран ажиллаж байна.

Компанийн 2026 оны дотоод сургалтын төлөвлөгөөнд удирдлага, манлайллын ур чадварыг сайжруулах, компанийн эерэг соёлыг төлөвшүүлэх, ажилтны урам зоригийг нэмэгдүүлэх, мэргэжлийн болон албан тушаалын тодорхойлолтод заагдсан туршлага, ур чадварыг нэмэгдүүлэх, хүний хөгжил, дижитал чадварыг сайжруулахад чиглэсэн нийт 31 төрлийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Энэ хүрээнд ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Политехник коллежтой хамтран 22 оюутныг төмөр замын мэргэжлийн сургалтад хамруулсан, Төв аймгийн засаг даргатай Санамж бичиг байгуулж 10 суралцагчдад Төмөр замын чиглэлээр Чадамжийн гэрчилгээ олгосон. Мөн Төмөр замын салбарын техник технологийн шинэчлэл, дижитал хяналтын тогтолцоо, өргөдлийн нэгдсэн системийг хөгжүүлэх, шинэ технологид суурилсан хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, шинэ технологийн хэрэглээг нэвтрүүлэхэд чиглэсэн богино хугацааны сургалтуудыг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Төмөр замын мэргэжлийн техник, технологийн коллежтой хамтран зохион байгуулсан бөгөөд суурь бүтцийн газраас 20 ажилтан, санхүү, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн газраас 15 ажилтан, тээврийн удирдлагын газраас 20 ажилтан тус тус хамруулсан.

Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, үр дүнг үнэлэх, урамшуулах, хариуцлага тооцох ажлын хүрээнд Гүйцэтгэх захирлын 2017 оны А/29 дүгээр тушаалаар баталсан “Ажлын гүйцэтгэлийг тайлагнах, дүгнэх, урамшуулал олгох журам”-ын дагуу ажилтнууд улирал бүр тайлан гаргаж ажилладаг бөгөөд компанид тогтвор суурьшилтай ажилласан, ажлын гүйцэтгэлээрээ манлайлан ажилласан ажилтнуудыг шагнаж урамшуулсан Үүнд:

- Хөдөлмөрийн хүндэт медалиар -1
- Хууль зүйн тэргүүний ажилтан -1
- Санхүү банкны тэргүүний ажилтан -4
- Хүндэт төмөр замчин -9

Сахилга хариуцлагын талаар: Техникийн хэвийн ажиллагааг алдагдуулсан, хөдөлмөрийн гэрээ, хэм хэмжээ, стандартыг мөрдөж ажиллаагүй ажлын хариуцлага алдсан 48 ажилтанд хариуцлага тооцон, хөдөлмөрийн дотоод журам, холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцон ажилласан. Үүнд:



“Монголын төмөр зам” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн гүйцэтгэл 100 хувийн хэрэгжилттэй байгаа бөгөөд Шилэн дансанд 7 хоног, сар, улирал, жилээр тавигддаг мэдээллүүд хуулийн хугацаанд, мөн хуульд заасан хэлбэрээр тогтмол тавигддаг. 2025 онд Зам, тээврийн яамнаас компанийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний тайланд 100 хувийн гүйцэтгэлтэй сайн үнэлгээ авсан ба Үндэсний аудитын тайланд “2025 онд шилэн дансны www.shilendans.gov.mn сайтад байршуулбал зохих 182 мэдээлэл, 348 гүйлгээг хугацаанд нь бүрэн оруулсан ба энэ нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн” гэж дүгнэсэн.